

**“ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙ  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2020-04-29

Мөрөн

**Хурал:** Хөвсгөл аймаг Мөрөн сумын 8-р багт байрлах “Хөвсгөл Хүнс”ХК-ийн өөрийн хурлын зааланд 2020 оны 04-р сарын 29-ны өдрийн 17.00 цагт эхлэв.

**Хурлын ирцийг** “Хөвсгөл Хүнс” ХКомпанийн ТУЗ-ийн Хурлын дарга Л.Дашцэрэн ирцийг 83.2 хувь байгааг мэдэгдэж хурлыг нээж.

**Хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулав.**

- Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг батлах
- Хянан шалгах зөвлөлийн тайлан
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Ногдол ашиг тараах эсэх
- Компаний ТУЗ сонгох

**Хурлын дарга Л.Дашцэрэн-** Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулав.

**Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр-** Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

**Гүйцэтгэх захирал Л.Цэрэнжав-** Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан

- Компанийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцүүлэв.

**Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр -** Хянан шалгах зөвлөлийн тайлан

- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Ногдол ашиг тараах эсэх
- Компаний ТУЗ сонгох зэрэг асуудлыг хэлэлцүүлж санал хураалт явуулав.

2019 оны жилийн эцэст ашиггүй ажилласан тул ногдол ашиг хувиарлах боломжгүй болсон.

За дээрхи асуудлуудтай холбоотой санал хүсэлт байна уу?

**Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Ж.Алтангэрэл-**  
Тооллогын комиссын дүнг танилцуулав.

**Хурлын дарга Л.Дашицэрэн-** Тооллогын комиссын дүнг үндэслэн тогтоолын төслүүдийг батлуулж уншиж танилцуулав.

**Гүйцэтгэх захирал- Л.Цэрэнжав** - 2019 онд талх талхан бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулж сав баглаа боодлыг шинэчлэн сайжруулж шинэ савлагаатай болголоо. Ингэснээр талх талхан бүтээгдэхүүний өнгө үзэмж сайжирч хэрэглэгчийн худалдан авах түвшин дээшилсэн. 2019 онд компаний ашиг орлогыг нэмэгдүүлж ажиллуулах тал дээр анхаарч бизнес төлөвлөгөөнд зарим зүйлүүдийг тусгасан.

Мөн нөөжилсөн бүтээгдэхүүний цехийн тасралтгүй ажиллагааг хангах жилийн дөрвөн улиралд үйлдвэрлэл явуулдаг байх адуу үхрийн мах нөөшлөх хатаах мөн загас үржүүлгийн аж ахуй байгуулахаар шаардлагатай газрын асуудлыг шийдүүлээд ажиллаж байгаа бөгөөд бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зах зээлд нэвтрэх тал дээр анхаарч ажиллаж байна. Манай компани нь 2020 онд сургууль цэцэрлэгийн 100 гаруй сая төгрөгийн тендерт шалгараад байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 18.10 минутад хаав.

ТАНИЛЦСАН: ТУЗ-ИЙН ДАРГА

Л.ДАШЦЭРЭН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

С.ОТГОНБААТАР

